

Дээд номын ёс галын шастир, тонилохуй мөрийг тодруулагч зул
хэмээгдэх оршвой зохиолын тухай

Хүрэлбаатарын БИРААСҮРЭН*

Монгол Улс, Улаанбаатар,
ШУА-ийн Хэл зохиолын
хүрээлэнгийн Сурвалж бичиг,
төвөд судлалын салбар

Received: Aug 21, 2024

Revised: Aug 22, 2024

Accepted: Nov 11, 2024

Хураангуй: Энэхүү өгүүллээр Төвөдийн эрдэмтэй лам Агванпунцагийн туурвисан Галын шастир хэмээх зохиолыг танилцуулж байна. Монголын алдартай оточ лам Ишданзинванжил хэдийгээр арай өмнөхөн нь Галын шастир нэртэй хос ёсны сургаалыг туурвисан боловч дахин зохиох болсон нь анхаарал татаж байна. Агванпунцагийн туурвисан Галын шастир нь авч үзэж буй сэдвийн хүрээндээ нэлээн нарийн нарийн элементүүдийг оруулснаараа онцлог байна. Чухамдаа бол энгийн сүсэгтэн олны хувьд явдал мөр хичээх нь гол болдог бол дунд түвшиндээ үзэл онол голлодог ба дээд түвшнийхэн бол аг тарнийн гайхамшиг мэдэрдэг, ил далдын рид шид үзүүлэх хэмжээнд тулдаг онцлогийг дээрх сургаалаар бүрэн харуулахыг зорьсон. Ингэснээрээ уг сургаал бага, дунд, их төрөлхтөн бүгдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц бөгөөд хүрсэн хүрснийхээ хэмжээ тунд тааруулан хүртэхэд тун тохирсон шинжтэй байна.

Түлхүүр үг: Шастир, сургаалын яруу найраг, эрдэмтэй лам нар, төвөд шүлэг

* © Х.Бираасүрэн 2024
Email: biraasuren@gmail.com

Some Notes on Another Fire Shastra

BIRAASUREN Khurelbaatar

*The Sector of the Textology and Tibetan Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia*

Abstract: *In this article, we present a piece of work called The Shastra of Fire, written by the learned Tibetan monk Agwanpuntsag. Ishdanzinvanjil, a famous monk of Mongolia, created a same doctrine called Fire Shastir a little earlier, but it is noteworthy that he started to re-compose it. Agwanpuntsag's shastra of fire is characterized by the inclusion of very detailed elements within the scope of the subject under consideration. As a matter of fact, for ordinary devotees, practice is the main thing, while at the middle level, theory is the main focus, and for those at the higher level, they transforming the wonders of Tantra, and they are able to show hidden magic through the above teaching. In this way, the teaching is able to fully meet the needs of all small, medium, and large people, and it is very suitable for receiving according to the amount of what has been achieved.*

Key words: *shastra, didactic poetry, scholar lama, tibetan verse.*

1. Удиртгал

Тус өгүүлэлд Төвөдийн эрдэмтэн Агванпунцагийн зохиосон галын шастир хэмээх сургаалын зохиолыг товч танилцуулж байна. Ингэхдээ тухайн бүтээл бий болсон нөхцөл, шалтгаан болон ёс уламжлалыг давхар хөндсөн бөгөөд улмаар зохиогчийн товч намтар, зохиолын товч агуулгыг багтаахыг зорилоо.

2. Судалгааны арга

Эх сурвалжуудын бүртгэн цуглуулж харьцуулан ажиглалт хийсний дараа зохиогчийн намтрыг хэсэгчлэн орчуулж оруулав. Мөн зохиолын товч агуулгыг энгийн ойлгомжтой байдлаар төвөд хэлнээс орчуулан зарим бадаг шүлгийг тайлбарласан.

3. Үндсэн хэсэг

Энэхүү сургаал нь Гүнгийн зуугийн гэгээн буюу шүлэгч Ишданзанванжилын туурвисан Галын шастир хэмээх сургаалын зохиолтой ижил хэлбэр агуулгатай бичигдсэн бүтээл болно. Чухам яагаад ингэж дуурайн зохиол бичих болсны учрыг олон янзаар таамаглаж болох боловч голдуу номын ёсны дагуудаа бол номлох, туурвих, тэмцэх гэсэн гурван үйлийг эрхэм болгодог жинхэнэ номын ёст хувраг лам нарын тухайд авч үзвэл байж болох ердийн, хэвийн зүйл юм. **Номлох** гэдэг нь сурсан эрдэм чадлаа бусдад зааж сургахыг хэлж байгаа бол, **туурвих** гэдэг нь өөрийн сурсан мэдсэнээ ном зохиол

хэлбэрээр хойч үедээ үлдээх, **тэмцэх** гэдэг нь би ингэж үзэж, бодож байна гэдгээ харилцан маргалдах, хэлэлцэх байдлаар зөв буруугаа онож мэддэг уламжлалтай байсан. Энэ ёсны дагуу хэн нэгэн эрдэмтэй лам нар ном бүтээл туурвисны хариу болгож өөр бас хэн нэгэн сөргүүлэн ном зохиол туурвих үзэгдэл нэлээдгүй гарч байсан. Монголчууд өөр зуураа иймэрхүү номын хаялцаан хийхийн сацуу, төвөд монголын мэргэд хоорондоо бас ийм төрлийн ном зохиолууд туурвисан жишээ цөөнгүй.

“1767 онд II Жанжа Ролбидорж (Лалидабазар, 1717-1786) “Эх юүгээн таньсны худал үг хадны цууриан яруу дуун” хэмээх гүн ухааны дуулал шүлэглэлийг зохиосон юм. Үүнд Төвөдийн Гончигжигмэдванбо (1728-1791) “Төв үзлийн дууллын тайлбар үгийн зул”, Ачит номун хан Лувсамдамбаравжаа (1759-1816) “Үзлийн бясалгалын эгшиглэлийг танин барихын тайлбар “би”-д баригчийн дайсны өмгийг дарах мэс-хувь төгөлдөр лянхуаг мөшөөлгөгч наран”, Халхын эрдэнэ мэргэн бандид Ишсамбуу (1847-1896) “Эх юүгээн танин ханьсахын хуурмаг дуулал-шүтэн гарсан хадны цууриан эгшиг дуун”, “Эх юүгээн танин барихын газрын хуваарь бясалгалын эгшиглэлийн тодорхой үес”, Жанжсин Чойрын хувилгаан Агванданзанням (1882-1937) “Үзлийн бясалгалын эгшиглэлийг танин барихын газрын хуваарь үгийн тайлбар” зэрэг үг, утгын нэмэлт тайлбаруудыг хийсний дээр бас тухайн зохиолын судар тарнийн хоёр ёсны утга санаан дээр Төвөд, Монголын номын мэргэд харилцан зөрөөтэй санал бодолтой байсан байна. “Эх юүгээн танин барих” хэмээх эл зохиолын тухайд Ачит номун ханы (Лувсамдамбаравжаа) хийсэн тайлбар дахь зарим маргаантай зүйлд Төвөдийн хэд хэдэн мэргэд нийлж нууц нэргүй хатуу хориглон шүүмжилсэн бичгийг илгээсэнд хариу болгож, Халхын Жэдор хамбын хувилгаан Агванхайдав (1779-1838) “Галын оньсон хүрд” хэмээх нэртэй хориглон шүүмжилсэн бичгийг барьж мөн хариуд нь Төвөдийн Балман цан Гончигжалцан (1764-1853) “Нигүүлсэхүйн далай” хэмээх хориглон шүүмжилсэн бичгийг хийсэн бөгөөд үүний нь хариуд Халхын Их хүрээний бичээч цорж Агванцэрэн “Их зааны хүрхрэх дуун” нэрт хориглон шүүмжилсэн бичгийг илгээсэн бол мөн үүний нь эсрэг Амдо төвөдийн Гонлүн хийдийн Гончигжамц “Арслангийн хүрхрэл” хэмээх хариу шүүмжийг хийж, бас үүний нь хариуд Богдын Их хүрээний шавь Мипамнамжил “Хангардийн эгшиг дуун” нэртэй хориглон шүүмжлэх бичгийг барьжээ. Гүн ухааны зөвхөн нэгэн дуулал шүлгийн тухайд ингээж Төвөд, Монголын номын мэргэд бие биесийн үзэл бодлыг мохоон шүүмжилсэн долоон шүүмжийн бичгийг гаргаж байсан бөгөөд тэгэхдээ тэдгээр шүүмжийн бичгүүдээ ихэд ёгтоор нэрлэж нэгийн омгийг нөгөөгийн хүчээр ялан дийлэх бэлгэдлээр хамгийн анхлан зохиогдсон

хориглон шүүмжилсэн бичигт өгүүлсэн буруу ухаарлын хорт өргөсийг шатаан түймэрдэх санаагаар Агванхайдав өөрийн шүүмжийг “Галын оньсон хүрд” хэмээн нэрлэж түүний эсрэг дараагийн зохиогдсон хариу шүүмжийг галын хүрд их далайн усанд буувч огт аюулгүйн үлгэрээр “Нигүүлсэхүйн далай” хэмээн нэрлэсэн байхад түүний дахин хариу шүүмжийг “Их зааны хүрхрэх дуун” хэмээн далайн хуурмаг нэрийг баригч цөөрмийн усанд халуунд энэлсэн их хүчит цагаан заан орж хүрхрэн сэрүүцэхдээ булингарт шалбааг болгохын үлгэрээр тийн нэрлэсэн бол мөн үүний хариу дараагийн шүүмжийг “Хан гардийн эгшиг дуун” хэмээсэн нь арслан хэдийвээр араатны хаан боловч жигүүртний хаан хангарди түүнээс үлэмж хүчтэй гэсэн санаагаар урьдах урьдхаас хүчий нь давуулан нэрлэжээ. (Хүрэлбаатар, 2002)

Номч хамба Агванпунцаг нь 1882 онд Амдогийн Рэвгон хэмээх нутагт Эцэг Содномжал, эх Дашжид хоёрын хүү болон мэндэлжээ. Багаасаа хувилгаанаар тодорч, таван насандаа ширээнд залагдсан. Жэ Пунцагданпилийг багшид шүтэж унших бичих тэргүүтэй номын ёсонд хөтлүүлэв. Жэвзүн Ринчиндоржийн өмнөөс равжүн сахил хүртэж, Лувсандамбийжалцан хэмээх нэр хайрлав. Энэ багшаасаа Цогт Очир Аюулгагчийн эрх хүртэж Мижиддорж хэмээх тарнийн нууц нэр авав. Долоон наснаас гучит, тэмдгийн орлого тэргүүтэй хэл зүйн ном ба зохист аялгуу буюу яруу найргийн онол зэрэг нийтийн ухааны ном сударт суралцаж эхлэв. Найман нас сүүдрийн үед Ронбо Галдандамбийжалцангийн өмнөөс завсрын тойн ба гэцэл сахил залав. Чойрт орж Дондовжамц хэмээх багшаар Дүйра, Лориг, Дагриг тэргүүтэй буддын логикт суралцав. Улаан малгайт бандид Гэндэнданзанжамц болон Шидтэний эрхин Жигмэдсамдан ринбүүчи нараас Цагаан шүхэртийн эрх ба Лэгдэнчэдсүмийн даган соёрхол, Жигжид, Дэмчиг, Гүнриг, Түгжчэнбийн эрх, даган соёрхлын аймаг олонтоо сонсов. Насан сүүдэр хорьтойдоо Жэ Дамбийжалцангийн өмнөөс гэлэн сахил залав. Удаа дараагаар Улаан малгайт бандида Гэндэнданзинжамц, Дүнчэн Пэрэнлэйжамц, Лахо Доржчан Авхиа, Гүнтэн Лодойжамц тэргүүтэй олон мэргэдийг багшид шүтэв. Судар дандарын гүн номыг олонтоо сонсоод, мөн хэл шинжлэл, яруу найргийн онол, найруулга зүй болон анагаах ухаан тэргүүтэй нийтийн ухааны ай савд ч мэргэжин сайжрав. Ялангуяа дүйра, тэмдэгт ухаан, ум, парчин тэргүүтэй чойрын номд машид мэргэжсэнээр их зарлиг боть нугуудын тааллын утгыг ухаарахдаа тэнцэх ханиас хагацав. Риво Дашчил, улаан хаалгат Гандан Пунцаглин, Ронбо Тойсомлин тэргүүтэй Амдуугийн алдартай хийдүүд ба нутаг орноос гарч олон хийд орноор номын хэслэг хийж, шавь сүсэгтэн олонд даган соёрхол, хөтөлбөр тэргүүтнийг цаглашгүй их хүртээн зохиов. Ганжуурын лүн хүртээх үед нэг өдөрт л хоёроос гурван боть хүртээж байсан гэдэг. Сахил санваар хайрласан нь ч тоо томшгүй болсон. 1936 онд Банчин богд Гүмбүмжамбаалин хийдэд залрах

үеэр бараалхан золгосон ба түүний номын их үйлийг хөхиүлэн дэмжиж Номч хамба Агванпунцаг хэмээх цол хайрлаж, тамга, номт малгай тэргүүтэй хамбын иж бүрэн хэрэглэлээр шагнасан юм. 1938 онд номын хийд Ганца Даржаалин хэмээхийг барьж босгон сожон тэргүүтэй гарын авлагыг сайтар тогтоов. Зарлигийн рашаанаар ундаалсан шавь нар нь Амдуу болон Монголын нутагт олноороо гарав. Түүний зохиол бүтээлээс товчхон дурдвал Богд ламын айлдсан бага Бодь мөрийн зэргийн тэмдэглэл, бага Бодь мөрийн зэргийн газрын хуваарь, яруу үндэслэсний увдис сэтгэлийг номхотгогч эрдэнийг эрхшээгч хаан, галын шастир тонилохуйн мөрийг тодруулагч зул, Төмрийн шастир сайн номлол хэрэгтэй бүгдийг татагч гох, эрдэнийн шастир сайн номлолыг эрхшээгч хаан тэргүүтэй гурван боть сүмбүмтэй. Зарим ном нь нутгийнх хийд оронд барлагдаж байсан.

Одоо галын шастир зохиолынх тухай ярья. Дээр өгүүлсэнчлэн Ишданзанванжилын Галын шастираас ялгаатай талыг нь дурдвал:

1. Уг сургаалаа ерөнхий галын мөн чанартай зүйрлэж бичсэн гэхээс илүүтэй нэрд тодорхой дурдагдсан зулын шинж байдалтай их төлөв уялдуулж бичсэн.

2. Гүнгийн зуугийн гэгээний сургаалыг бодоход гадаад иргэний асуудлаас илүүтэйгээр шашны дотоод хуврагийн дүр байдалд түлхүү анхаарсан.

3. Ерөнхий шашны ойлголтын хэмжээнд буян нүглийг заан сургасан боловч илүү нарийвчлан төгс гэгээрэлд хүрэх үе шатуудыг тусгайлан номлож сургасан нь анхаарлыг зүй ёсоор татаж байна.

Тахилын шүлэгт өгүүлэхдээ:

ཡེ་ཤེས་འོད་གྱི་སྒྲུང་བ་ཡིས།།

མ་རིག་ཐུན་བ་སེལ་མཛད་བ།།

ཐུབ་བ་སྒྲོན་མེ་རྒྱལ་ལ་འདུད།།

ཐུགས་རྗེས་འགྲོ་ཀུན་རྗེས་སུ་བྱུངས།།

Билиг оюуны хурц гэрлээр

Балар мунхгийг нэвт гийгүүлээд

Бадамлах зул шиг багш бурхад минь

Барчид нүгэлт биднийгээ өршөө

гэж шүлэглэсэн ба гэрэл харанхуйн мөн чанарыг эсрэг харшуулан гэгээрэлд хүрсэн бурхан бодисад гэм нүгэлт өчүүхэн эгэлүүдтэй сөргүүлэн тавьсан.

སྒྲུམ་གྱིས་རབ་བཟུང་སྒྲོང་བུ་ལས།།

མེ་ཡི་འོད་ཟེར་མཆེད་བ་བཞིན།།

དད་བ་བརྟན་ན་དེའི་རྒྱུད་ལ།།

ཆོས་གྱི་སྒྲུང་བ་རྒྱས་བར་འབྱུང།།

Нүнжиг сайтай зулын гол нь
Тунчиг сайхан гэрэлтэх мэт
Сүсэг сайтай шавийн сэтгэлд л
Багшийн эрдэм халдах болдог

ГЭСЭН НЬ ЕРӨӨСӨӨ ЯМАР Ч ЮМАНД ХҮСЭЛ СОНИРХОЛ ТӨРЖ БАЙЖ ӨСӨЖ ДЭВЖДЭГИЙН АДИЛ БУРХНЫ СУРГААЛ Ч ҮҮНИЙ АДИЛ БАТ САЙН СҮСГИЙН СЭТГЭЛ ДЭЭР ТОГТОХЫГ ХАРУУЛЖ БАЙНА.

རེན་ཆེན་ལྷོན་མ་བཞེན་བྱས་ན།
 ལུན་བ་སེལ་ཞིང་སྤང་བ་གསལ།
 དེ་བཞིན་དམ་པའི་བཤེས་ལ་བཞེན།
 གཏི་ལུག་ལུན་སེལ་ཤེས་རབ་གསལ།

Эрдэнэт зулын гэрэлд шүтсэнээр
Эргэн тойронд харанхуй арилдаг
Эрдэмт багшийн сургаалд шүтсэнээр
Элмэг тэнэгийн мунхаг арилдаг

гэж сүсэглээд зогсохгүй сургаал зарлигийг амьдрал ахуйдаа хэрэглэж явахыг сургасан.

མུན་འཕྱིལ་བྱང་ཆེ་སྒྲོན་མེ་སྤང།
འོད་ལ་བཞེན་ནས་གང་འདོད་ཚུམ།
མི་ཤེས་སྐྱབས་སུ་བཤེས་བཞེན་བསྟེན།
དེ་ནས་ཐོས་བསམ་གང་འདོད་ཚུམ།

Түнэр харанхуйд зулаа асаах
Түүний гэрэлд номоо хичээх
Түрвэлгүй эрдэмт багшийг шүтэж
Түвэг бэрхшээл бүгдийг давах

зүдрэхийн цагтаа харин багшийн ачаар зовлонг гэтэлдэг багшийг ёсчлон шүтвэл хэрэг үйлс аяндаа бүтэхийг үзүүлсэн.

སྒྲོན་མའི་འོད་ནི་ཆེས་གསལ་ཡང་།།
 འོད་བ་རྣམས་ལ་བན་མི་འགྱུར།།
 བཤེས་གཉེན་ཉི་མ་གསལ་གྱུར་གྱང་།།
 དད་བརྟེན་མིག་བྲལ་ཅི་སྟེ་བན།།

Зулын гэрэл хэчнээн саруулхан ч
Зүдэг сохорт тусаар багатай
Нар шиг ачтай багшийн сургаалыг
Насад хичээж дагавал тустай

མར་མེ་ཡུལ་རིང་གནས་མི་འགྲུང།
འཆི་སྐུ་མི་འགྲུང་དགོན་པའི་ཁྱོད།
ཆེ་སྟོག་འདི་ནི་འཇིག་པར་སྟ།

Зуурын хүчтэй салхинд
Зулын гал бөхөлздөг
Зуурдын энэхэн насанд
Зуу хүрэх нь ховорхон

མར་ཁྱའི་མང་རྩུང་ཨ་ལོ་གེ།

གནས་ཡུན་རིང་ཐུང་དེ་ལ་བརྟུག་།

ཆེ་སྟོག་ཡུན་རིང་གནས་མི་གནས།།

སྒྲོན་གྱི་ལས་དང་རྒྱུན་ལ་བརྟེན།།

Бадамлан асах зулын өнийг
 Бараглаж түүний цөгцөөр хэмждэг
 Базаалтай урт наслах эсэх нь
 Баараггүй урьдын буянд харгацдаг

ཇི་ཙམ་དེང་ཡང་ཆེ་སྟག་ནི།

བསོད་ནམས་ཆད་བཞིན་དེ་ཙམ་སྟེ།

སྒྲུང་འོད་གནས་ཡུན་དབྱེད་པ་ན།

སྒྲིག་གི་ཆད་བཞིན་དེ་ཙམ་སོ།།

Улалзан асах зулын удааныг
Уг цөгцний хэмжээгээр мэддэг
Урт наслах богино наслах ч
Урьд хураасан буянаар болдог

སྒྲུལ་དང་མེ་ཡི་རྒྱུན་བྱས་ནས།།

མར་མེད་སྟོང་བུ་རྣམ་པར་སྟེག།

ལས་ཉོན་དབང་གིས་དཔྱལ་བའི་འགྲོ།

བཟོད་དཀའི་ཆ་གང་གསུང་བས་གཟེར།།

Тостой зулд гал авалцсанаар
Тортогт голыг машид шатаадаг
Үйл нисваанисаар тамд төрөөд
Өгүүлшгүй бэрх зовлонг эдэлдэг

སྒྲིང་བྱའི་ཁོང་ནས་མེ་འབར་ཆོ།།

དུ་བ་ཆེལ་ཆེལ་ཆ་ཆ་འཕྲོ།།

ཡི་དྲགས་བྱིལ་སོང་མ་རུངས་ནམས།།

Улалзах зул бадамлахын хэрээр

Там бирд адгуусны төрөлтөнд ч

ཐུན་པའི་དབྱང་གིས་མི་བརྗེ་བ།།

ངན་འགྲོའི་ཐུན་པར་མི་ལྟང་བའི།།

Айхавтар харанхуйн дунд үл төөрөх

Аймшигт муу заяаны халилд үл унах

འོད་ལ་བསྟེན་ན་སྒྲུང་བ་སྟེ།

དགོ་དང་སྒྲིག་པའི་ལས་འབྲས་ཀྱིས།

Саруул гэрлийн ачаар эргэн тойрон үзэгдэх

Сайн муу үйл, буян нүглийн ялгалаар

Дээрх бадаг шүлгүүдээс харахад зулын харагдах байдлаар үлгэрлэж бурхны шашны гол гол ойлголт ухагдахууныг энгийнээс нь аваад эцсийн төгс гэгээрэлд хүртэлх бүх л үе шатуудыг тоочин шүлэглэсэн нь хэр баргийн эрдэмтэй лам нараас гарахааргүй нарийн ажиглалт өөрийн бодит туршлагад тулгуурласан болох нь тодорхой харагдаж байна. Тухайлбал багшийг шүтэх ёс, бодь сэтгэл, үйлийн үр, буян нүгэл, сайн муу төрөл, зургаан барамид, дөрвөн хураах, живэх догшрох сэтгэлийн байдал, хоосон чанар, хослон орохуй, хоёр чуулган зэрэг ойлголтуудыг багтаан шүлэглэсэн байна.

4. Дүгнэлт


юмс үзэгдэлд ойртуулан жиших байдлаар сурган номлосон нь авч хэрэглэх сүсэгтэн олны тухайд амар хялбар ойлгомжтой болсон нь эргэлзээгүй. Энэхүү уламжлалаар таван махбодын шастир нэртэй сургаал шүлгүүд Төвөд, Монголд ихээхэн алдаршсан бөгөөд бид бүгд тодорхой хэмжээнд судалгааны эргэлтэд оруулж байгаадаа баяртай байна.

Ном зүй

Dung dkar tshig mdzod chen mo. (2002). Бээжин. [*Dungaryn nebterhii toli*, [Encyclopedia of Dungkar]. Peking. 2002]

legs bshad zla ba'i snang ba. (2006). [*Sain nomlol sarny gerel*. [Eloquent sayings of moonlight. 2006]

Хүрэлбаатар, Л. (2002). *Судар шастирын билиг*. [L.Khurelbaatar. *Sudar shastiryn bilig* [Wisdom of sutra and shastra] Ulaanbaatar. 2002]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.

Их бодь мөрийн зэрэг бүтээлийн монгол орчуулгууд

Арилдийн БУРМАА*
Япон улс, Кобэ хот,
Гадаад Хэлний Их Сургууль

Received: Sep 1, 2024

Revised: Oct 7, 2024

Accepted: Oct 23, 2024

Хураангуй: Их бодь мөрийн зэрэг нь гэлүгвагийн шашныг үндэслэгч богд Зонхава (1357-1419)-ын зохиол юм. Уг бүтээлээрээ Төвөдийн буддизмын гол онцлог бүхий “Мөрийн зэрэг” үзлийг айлдсан байдаг билээ. Энэтхэгийн Викрамашила хийдийн хамба лам асан Атиша (982-1054) Төвөдөд залагдаж ахуй хугацаандаа туурвисан Бодь мөрийн зул зохиолоороо анх “Мөрийн зэрэг” үзлийн суурийг тавьсан гэдэг. Уг үзлийг эцсийн шатанд хөгжүүлсэн боловсронгуй хэлбэр нь Их бодь мөрийн зэрэг гэж хэлж болно. Уг бүтээл монгол хэлнээ олонтоо орчуулагдаж ирсэн хэдий ч хэн хэзээ орчуулсан хэдэн төрлийн орчуулга байдаг хийгээд тэдгээр нь одоо хаана байгаа нь тодорхойгүй байсаар байсан юм. Энэхүү судалгаагаар нийт 7 төрлийн орчуулга буйг олж тогтоов.

(1) Алтангэрэл увшийн орчуулга (орч. он 1655)

(2) Зая бандидын шавь Дагийн орчуулга (орч. он 1662-1670)

(3) Урадын мэргэн равжамба Гунгаажамцын орчуулга (орч. он XVII зууны сүүл хагас)

(4) Зонхавын сүмбүм дэх орчуулга (орч. он 1730 оны сүүл хагас)

(5) Лувсанцэнпэлийн орчуулга (Lubsangcempil, 1761-1834) (орч. он 1812)

(6) Галсанжамбын орчуулга (1816-18??) (орч. он 1870)

(7) Т.Булганы орчуулга (1959~) (орч. он 2004-2007)

Энд эдгээр орчуулгын хадгалагдаж буй газар, орчуулагч, орчуулагдсан оны талаар хэрхэн тодруулсан хийгээд хоорондын холбоо хамаарлыг авч үзлээ. Орчуулагч нь тодорхойгүй төгсгөлийн үггүй эхүүд ч байгаа тул мөргөлийн шүлгээр харьцуулав.

Түлхүүр үг: Их бодь мөрийн зэрэг, Богд Зонхав, Мөрийн зэрэг

* © А.Бурмаа 2024

Email: burmaa_gej@yahoo.com